

Бүсийн болон нэрэмжит тэмцээний тайлангууд:

2019 оны 1 дүгээр сарын 14-16 хооронд Хэнтий аймагт зохион байгуулагдсан Сент-Луис олимпын зөвлөлийн нэрэмжит олон хотын өсвөр үеийн волейболын нээлттэй тэмцээнд Говьсүмбэр аймгийн Б.Баярмаа, Б.Жамбаноров дасгалжуулагчтай 13-16 насны өсвөрийн багийн тамирчид оролцсон. Тус тэмцээн эрэгтэй 12, эмэгтэй 12 баг оролцсон.



Дорноговь аймгийн Жүдо бөхийн өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 03 сарын 14,15-нд амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд Говьсүмбэр аймгийн баг тамирчид амжилттай оролцож -38кг жинд Э.Тэмүүлэн алт, 42кг жинд Ц.Алтангэрэл мөнгөн, О.Жаргалсайхан хүрэл медаль, 60кг жинд Л.Лувсанжамц мөнгө, 48кг жинд Б.Аззаяа, 27кг жинд М.Бүүвэйбаатар нар хүрэл медаль хүртлээ.



Монголын хөлбөмбөгийн холбооноос 21 аймгийн аварга шалгаруулах 16 хүртэлх насны футзалын "Үндэсний цом-2019" тэмцээнийг Дархан-Уул аймагт зохион байгууллаа. Тэмцээнд Б.Буянтогтох ахлах дасгалжуулагчтай, Э.Эрхэмбаатар туслах

дасгалжуулагчтай, Б.Дөлгөөн ахлагчтай оролцсон манай баг мөнгөн медаль хүртлээ. Манай баг С хэсэгт орж эхний тоглолтдоо Увс аймгийн багтай 5:5-аар тэнцэж, Хөвсгөл аймгийн багийг 14:6-аар, Ховд аймгийн багийг 5:4-өөр хожиж хэсгээсээ нэгээр шалгарч Өмнөговь аймгийн багийг 9:1-ээр хожиж шилдэг 4-т шалгарсан.



2019 оны өсвөрийн шатарчдын улсын аварга шалгаруулах тэмцээнд Г.Харуулбаатар багшийн удирдлагад оролцсон манай аймгийн баг тамирчид 1 хүрэл медаль хүртлээ. Тэмцээний 6 хүртэлх насны хөвгүүдийн ангилалд 61 тамирчин өрсөлдөж манай тамирчин Б.Энхбүрэн хүрэл медаль хүртлээ.



Биеийн тамир, Спортын дунд сургуулийн нэрэмжит өсвөрийн үеийн шатрын “Тэмүүлэл” тэмцээн 2019 оны 03 сарын 16-17-ны Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулагдаж Говьсүмбэр аймгийн Харуулбаатар дасгалжуулагчтай баг тамирчид амжилттай оролцож, тамирчин П.Маргад 8 хүртэлх насны ангилалд алтан медаль, 6 насны ангилалд Б.Энхбүрэн 4-р байр эзэлсэн амжилт үзүүллээ.



Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Бөхийн “Боржигон дэвжээ” байгуулагдсаны 25 жилийн ойн арга хэмжээнд хүрээнд зүүн бүсийн аварга шалгаруулах жүдо бөхийн өсвөр үеийн тэмцээн 2019 оны 03 сарын 29-31-ны өдрүүдэд Бор-өндөр суманд 5 аймгийн 340 гаруй тамирчид хурд хүч авхаалж самбаа сорин өрсөлдлөө. Тэмцээнд Говьсүмбэр аймгаас 2 дасгалжуулагч 37 тамирчин оролцсон. нийт 2 алт, 3 мөнгө, 7 хүрэл нийт 12 медаль хүртлээ. Шилдэг эрэгтэй тамирчинаар Хаялга спорт клубын тамирчин М.Эрдэнэбат шалгарлаа. 5-р байранд М.Бүүвэйбаатар, Т.Бумдорж нар 5-р байранд улсын аварга шалгаруулах эрхээ авлаа.





Тэмцээнд эрэгтэй 5 эмэгтэй 6 баг оролцсоноос охидын багаас 1-р байранд Баярмаа дасгалжуулагчтай Говьсүмбэр аймаг, 2-р байранд Жаргалсайхан дасгалжуулагчтай Хэнтий аймаг, 3-р байранд Аяжан дасгалжуулагчтай Дорноговь аймаг, хөвгүүдийн багаас 1-р байранд Доржагдаг дасгалжуулагчтай Хэнтий аймаг, 2-р байранд Жамбаноров дасгалжуулагчтай Говьсүмбэр Эрчим баг, 3-р байранд Аяжан дасгалжуулагчтай Болдсүрэн ахлагчтай Дорноговь аймгийн баг тамирчид орж хүүхдийн наамдын шигшээ тэмцээнд оролцох эрхээ авлаа. тэмцээний шилдэгүүд охид. довтлогч Баттуяа Дорноговь, холбогч Ану Говьсүмбэр хамгаалагч Анужин Хэнтий аймаг, хөвгүүдээс довтлогч Энхбаяр Говьсүмбэр аймаг, холбогч Амгаланбаатар Говьсүмбэр аймаг, хамгаалагч Очирмаань Хэнтий аймаг тамирчид оролцлоо.



Хэнтий аймагт болсон Зүүн бүсийн сагсан бөмбөгийн 5*5, 3*3 -ын аварга шалгаруулах тэмцээн амжилттай болж өндөрллөө. Тус тэмцээнд 5 аймгийн 160 гаруй тамирчид өрсөлдөж, 3*3 төрөлд эрэгтэй 1-р байранд Хэнтий, 2-р байранд Дорноговь, 3-р байранд Говьсүмэр аймаг, эмэгтэй төрөлд 1-р байранд Говьсүмбэр, 2-р байранд Хэнтий, 3-р байранд Сүхбаатар аймаг

шалгарсан бол , 5*5 эрэгтэй төрөлд 1-р байранд Хэнтий, 2-р байранд Дорнод, 3-р байранд Сүхбаатар аймаг, эмэгтэй төрөлд 1-р байранд Дорно-говь, 2-р байранд Хэнтий, 3-р байранд Дорнод аймгийн баг тамирчид шалгарсан.



Булган аймагт болсон олон улсын нээлттэй "Булган-2019" Марафон гүйлтийн тэмцээн 2019 оны 05 сарын 4-нд Булган аймагт зохион байгуулагдсан. Тэмцээнд Говьсүмбэр аймгаас 2 тамирчин амжилттай оролцож Аймгийн Онцгой байдлын газрын тамирчин ОУХМ Д.Ариунжаргал 3-р байранд орж хүрэл медаль хүртлээ. П.Төгөлдөр 10-р байранд орсон.



Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Дорноговь аймгийн ЗДТГ, Монголын шатрын холбооны Дорноговь аймаг дахь салбар зөвлөл, аймгийн Биеийн тамир спортын газраас хамтран Монголын шатрын нэрт зүтгэлтэн, Монгол Улсын 6 удаагийн аварга, ОУ-ын шатрын холбооны мастер Жамбалдоогийн ЛХАГВААгийн нэрэмжит говийн бүсийн аймгуудын холимог насны 2019 оны аварга шалгаруулах шатрын тэмцээнийг 04 сарын 24- зохион байгууллаа. Тус тэмцээнд 4 аймгийн нийт 180 гаруй тамирчид оюун ухаан, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. Говьсүмбэр аймгаас шатрын спортын дэд мастер Г.Харуулбаатарын удирдлага дор оролцсон тамирчид 6 алт, 4 мөнгөн медаль хүртэж багийн дүнгээр ГУРАВДУГААР байрт шалгарлаа.

Өсвөрийн насны хөвгүүдийн 7-8 насны ангилалд Х.Дөлгөөн, 13-14 насны ангилалд Б.Болорсүх, охидын 7-8 насны ангилалд М.Маргад, 15-16 насны ангилалд Н.Мөнгөнсарнай, 17-18 насны ангилалд А.Энхдэлгэр нар алт, хөвгүүдийн 5-6 насны ангилалд Б.Энхбүрэн, 7-8 насны

ангилалд П.Баяр-Эрдэнэ, 17-18 насны ангилалд Э.Түвшинтөгс, охидын 11-12 насны ангилалд Б.Цовоо нар мөнгөн медаль тус тус хүртлээ. Насанд хүрэгчдийн эрэгтэйчүүдийн төрөлд спортын дэд мастер Б.Боорчи алтан медаль хүртлээ. Насанд хүрэгчдийн эмэгтэйчүүдийн төрөлд Б.Өнөтуяа шагналт 5-р байрт шалгарсан.



Монголыг тамирчдын баяр, Дэлхий олимпын гүйлтийн өдрийн хүрээнд "ГОВЬСҮМБЭР МИНИ ШАТАР 2019" Тэмцээн 2019.06.22-ний өдөр амжилттай зохиогдож өндөрлөлөө.

Тэмцээнд Хэнтий аймаг, Дорноговь аймаг, Өмнөговь аймаг, Дундговь аймаг, Говьсүмбэр аймгийн тамирчид оролцлоо.

Ингээд дүн гарахад :

6 Хүртэлх насны эрэгтэй ангилалд Б.Энхбүрэн/Говьсүмбэр/

6 Хүртэлх насны эмэгтэй ангилалд Г.Наранцацрах/Бор-өндөр/

7-8 насны эрэгтэй ангилалд М.Алтанхүү /Бор-өндөр/

7-8 насны эмэгтэй ангилалд Г.Эгшиглэн/Бор-өндөр/

9-10 насны эрэгтэй ангилалд Б.Цагаан-уул/Хэнтий/

9-10 насны эмэгтэй ангилалд М.Маргад /Говьсүмбэр/

тамирчид маань тэргүүн байр эзэллээ.

Говьсүмбэр аймгийн тамирчдаас Б.Энбүрэн алт, М.Маргад алт, Л.Сумьяа мөнгө, Х.Дөлгөөн хүрэл медаль авсан амжилтуудыг үзүүлсэн.



"Хос Мастер" шатарын академиэс 05 сарын 26-нд зохион байгуулсан "Шатар сонирхогч 2019 В" тэмцээнд Говьсүмбэр аймгийн тамирчин Б.Болорсүх мөнгөн медаль хүртсэн. тамирчин М.Маргад тусгай шагнал хүртлээ.



Улаанбаатар хотын 380 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан Ширээний теннисний аварга шалгаруулах нээлттэй тэмцээнд Говьсүмбэр аймгийн “Сансар хайрхан” спорт клубын өсвөрийн 15 тамирчин оролцож Ганцаарчилсан төрөлд тамирчин Г. Сэлэнгэмөрөн мөнгөн медаль, Д Нямбаяр хүрэл медаль хүртсэн.



Сэлэнгэ аймагт 2019 оны 06 сарын 30-нд Эрдэнэт хотод болсон "Fina world aquatics day" нэрэмжит тэмцээнд Говьсүмбэр аймгийн баг тамирчид амжилттай оролцож 1 алт, 18 мөнгөн, 11 хүрэл медаль хүртсэн.



Говийн бүсийн аймгуудын ахмадын спорт урлагийн наадамд амжилттай оролцоод ирлээ. СПОРТ: 3 алт (шатар эмэгтэй-Г.Бямбаа, теннис эмэгтэй-О.Наранчимэг, дартс эмэгтэй-О.Амарбаяр), 1 мөнгө (дартс эрэгтэй-С.Дорж), 4 хүрэл медаль (гар бөмбөг, шагай, эрэгтэй шатар, эрэгтэй теннис) хүртсэн амжилтаар 2-р байр эзэллээ.

УРЛАГ: 1 алт (язгуур урлаг-Г.Арилдий), 2 мөнгө (гоцлол дуу-Б.Энхтөр, харилцаа дуу-Б.Энхтөр, П.Дайриймаа), 2 хүрэл медаль (гоцлол хөгжим-Г.Арилдий, цэнгээнт бүжиг-С.Дорж, П.Дайриймаа) хүртсэн амжилтаар мөн 2-р байрт шалгарлаа.



Хэнтий Аймгийн Галшар сумнаа Монгол улсын аварга Ж.Дугар агсны нэрэмжит "ЗҮҮН БҮС 2019" тэмцээн амжилттай зохиогдож дүнгээ гаргалаа.

Говьсүмбэр аймгийн тамирчдаас дараах амжилтыг гаргалаа.

6 Хүртэл насны хөвгүүдийн ангилалд 2019 оны ӨСВӨРИЙН УАШТ-ний хүрэл медальт Б.Энхбүрэн шагналт 4-р байр

9-10 Насны хөвгүүдийн ангилалд Л.Сумьяа шагналт 4-р байр

13-18 Насны ангилалд 2014 оны "ЦОДГОР ХҮҮ" УАШТ-ний хүрэл медальт Б.Болорсүх шагналт 5-р байр

Насанд хүрэгчдийн ангилалд 2017 Оны сонирхогчдын ДАШТ-ний түргэн тоглолтын аварга ДМ Б.Боорчи хүрэл медаль

Насанд хүрэгчдийн ангилалд Багийн ахлагч ДМ Г.Харуулбаатар шагналт 4-р байр эзэлсэн амжилтуудыг гаргалаа.

Мөн 7-8 насны ангилалд оролцсон М.Ганэрд



амжилттай оролцсон тамирчны шагнал хүтрлээ.

Улаанбаатар хотноо гурав дахь жилдээ зохион байгуулагдсан “Ulaanbaatar international pro” жюү жицүгийн олон улсын тэмцээнд Говьсүмбэр аймгийн баг тамирчид амжилттай оролцлоо.Өсвөр үеийн насны ангилалд -27кг жинд М.Бүүвэйбаатар алтан медаль, -62кг жинд О.Пүрэвбаатар мөнгө, -50кг жинд Ц.Алтангэрэл хүрэл медаль, охидын -68кг жинд Б.Билгүүнмөрөн мөнгө медаль, 45 жинд Э.Тэмүүлэн, охидын 57кг жинд Х.Ариунзул нар шагналт 4-р байранд орсон амжилт үзүүлсэн.



Улаанбаатар хотноо “ХОС МАСТЕР” Академиэс зохион байгуулсан "Алтан намар 2019" Өсвөрийн шатарчдын тэмцээн 2019 оны 09.21-22 өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа.Тэмцээнд Говьсүмбэр аймгийн Г.Харуулбаатар багштай тамирчин Л.Сумьяа 10 хүртэлх насны ангилалд өрсөлдөж мөнгөн медаль хүртлээ.



“vizta” клубын нэрэмжит усан спортын нээлттэй олон хотын тэмцээн 2019 оны 10 сарын 12,13-нд Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулагдаж Говьсүмбэр аймгийн Говийн усчид амжилттай арвин оролцлоо. Тэмцээнд тамирчин О.Оргил 1 мөнгө, 2 хүрэл, Ж.Баярцогт 2 хүрэл, б.Норовсүрэн 1 мөнгө, М.маргад 1 хүрэл медаль хүртсэн бол охидын баг буухиа төрөлд алтан медаль хүртлээ.



Аймгийн аварга шалгаруулах тэмцээний арга хэмжээнүүд

2019 оны шатарын өсвөрийн үеийн аймгийн аварга шалгаруулах "Цодгор хүү" тэмцээн 01-р сарын 19-нд Хоёрдугаар сургуулийн урлаг зааланд амжилттай зохиогдож байгуулан өндөрлөлөө.

Тэмцээнийг Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Аймгийн шатарын холбоотой хамтран зохион зохион байгуулсан.

Тэмцээнд нийт өсвөрийн 50 тамирчин оролцож, 8 тамирчин улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхээ авлаа.



2019 оны Говьсүмбэр аймгийн өсвөрийн шатарчдын аварга шалгаруулах тэмцээн 02 сарын 02-ний өдөр 2-р сургуулийн спорт зааланд амжилттай зохион байгуулагдсан. Тус тэмцээнд 55 өсвөрийн тамирчид оюун ухаанаа уралдуулснаас

6 хүртэл насны хөвгүүдийн ангилалд Б.Энхбүрэн
8 хүртэл насны охидын ангилалд М.Маргад
8 хүртэл насны хөвгүүдийн ангилалд М.Ганэрдэнэ
9-10 насны охидын ангилалд Б.Мөнхгэрэл
9-10 насны хөвгүүдийн ангилалд Л.Сумьяа
11-12 насны охидын ангилалд Б.Цовоо
11-12 насны хөвгүүдийн ангилалд А.Ганзолбоо
13-14 насны охидын ангилалд Н.Мөнгөнсүвд
13-14 насны хөвгүүдийн ангилалд Б.Болорсүх
15-16 насны охидын ангилалд Н.Мөнгөнсарнай
15-16 насны хөвгүүдийн ангилалд Э.Цэлмэг
17-18 насны охидын ангилалд Г.Маралгуа 17-18 насны хөвгүүдийн ангилалд Г.Алтангэрэл нар тэргүүн байр эзэллээ.
2019 оны Өсвөрийн шатарчдын УАШТ-нд оролцох эрхээ авлаа.



Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах Даамны тэмцээнийг 03 сарын 10-ны өдөр БТСГ-ын сургалтын танхимд амжилттай зохион байгууллаа. Тэмцээнийг 5-н насны ангиллаар зохион байгуулж нийт 4 сургуулийн 50 гаруй тамирчид оролцлоо. Шалгарсан тамирчид улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхээ авсан.



Монгол Үндэсний соёлын үнэт өв сангийн нэгэн хэсэг үндэсний сурын харвааг хөгжүүлэх, өв уламжлалыг олон нийтэд сурталчлан таниулах, залуу үеийнхэнд өвлүүлэх, олон арван харваачдыг төрүүлэн гаргах, харваачдын ур чадварыг дээшлүүлэх, туршлага солилцох, улсын нээлтийн харвааны томоохон сорилго харваа болгох зорилготой аймгийн нээлтийн харвааг 5 сарын 19-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд цолтой болон залуу, өсвөрийн нийт 20 гаруй харваачид оролцоноос эрэгтэй, эмэгтэй, өсвөр насны эхний 3 байр шалгаруулж медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулав.

Эрэгтэй: Тэргүүн байр – “Жахрай мэргэн” сурын холбооны залуу харваач Б.Мөнхжаргал

Дэд байр – “Жахрай мэргэн” сурын холбооны харваач Спортын мастер, Аймгийн мэргэн Б.Батмөнх

Гутгаар байр – Онцгой байдлыг газрын харваач Спортын мастер Б.Цэрэндаш

Эмэгтэй:Тэргүүн байр – “Жахрай мэргэн” сурын холбооны харваач Спортын мастер Ж.Норжмаа

Дэд байр – “Жахрай мэргэн” сурын холбооны залуу харваач Х.Ариунжаргал

Гутгаар байр – “Жахрай мэргэн” сурын холбооны харваач Спортын мастер, Аймгийн мэргэн С.Туяагэрэл

Өсвөр нас:Тэргүүн байр – 5 дугаар сургуулийн сурагч Уранчимэг

Дэд байр – Дорноговь аймгийн харьяат 5 дугаар сургуулийн сурагч Найдан

Гутгаар байр – 5 дугаар сургуулийн сурагч Төгөлдөр нар шалгарлаа.



Уламжлал болгон зохион байгууладаг "Бага олимп" спортын наадам спортын 9-н төрлөөр зохион байгуулж байна. 09 сарын 28,29-нд футзалын тэмцээнийг зохион байгуулж 4 сургуулийн 20 багийн 190 гаруй тамирчид оролцсон.



10 сарын 12-нд Даамны тэмцээнийг 1-р сургуульд амжилттай зохион байгуулж 4 сургуулийн 4 насны ангилалд 90 гаруй тамирчид оролцсон.



10 сарын 13-нд шатарын тэмцээн 1-р сургуульд амжилттай зохион байгуулж 4 сургуулийн 6 насны ангилалд 65 тамирчин оролцсон.

Хөнгөн атлетийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 10 сарын 12-ны өдөр зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд 5 сургуулийн нийт 80 гаруй тамирчид оролцсон.



10 сарын сагсан бөмбөгийн хүүхдийг 3 насны ангилалаар 5 сургуулийн эрэгтэй, эмэгтэй нийлсэн 74 багийн 510 гаруй тамирчид оролцсон.



Уламжлал болгон зохион байгууладаг "Бага олимп" спортын наадмын Жүдо бөхийн 11 сарын 17-нд Аймгийн БТСГ-ын спорт зааланд зохион байгуулагдлаа. Тэмцээн 4 сургуулийн баг тамирчид эрэгтэй 9 жин, охидын 6 жинд хурд хүч авхаалж самбаа зорин өрсөлдлөө. Багийн дүнгээр Л.Амаржаргал дасгалжуулагчтай 3-р сургууль, 2-р байранд Батбаяр багштай 2-р сургууль, 3-р байранд 1-р сургуулийн баг тамирчид орсон.



Волейболын төрөлд 4 сургууль, Хаялга спорт клубын нийт бага насанд 17 багийн 84 тамирчин, ахлах насанд 23 баг нийт 161 багийн 216 тамирчид оролцсон.



Монгол Улсын гавьяат дасгалжуулагч Лувсандоржийн Цэдэнсодном агсны Волейболын спортод үзүүлсэн амжилт, алдар, гавьяаг мөнхжүүлэх зорилгоор Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 32-р тогтоолоор Лувсандоржийн Цэдэнсодном агсны нэрэмжит аймгийн аварга шалгаруулах насанд хүрэгчдийн Волейболын тэмцээнийг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ивээл дор жил бүр уламжлал болгон зохион байгуулахаар шийдвэрлэсэн билээ.

Эрэгтэй багийн төрөлд:

1-р байр Бизнес хөгжил

2-р байр БЗӨБ-ийн Цахилгаан түгээх сүлжээ

3-р байр Шивээ-Овоо ХК

Эмэгтэй төрөлд

1-р байр Бизнес ирээдүй

2-р байр Хаан банк

3-р байр ЕБ-ын 1-р сургууль

Эрэгтэй:

Тэгш тоглогчоор: Э.Оюунболд

Шилдэг довтлогчоор: Ж.Сугаржав

Шилдэг давуулагчаар: н.Эрдэнэбат

Шилдэг хамгаалагчаар: Б.Санчирбаяр

Шилдэг холбогчоор: н.Төгөлдөр

Эмэгтэй:

Тэгш тоглогчоор: З.Отгонтуяа

Шилдэг довтлогчоор: Д.Солонготуяа

Шилдэг давуулагчаар: С.Отгонцэцэг

Шилдэг хамгаалагчаар: н.Энхмөнх

Шилдэг холбогчоор: Д.Уянгатуяа





Уламжлал болгон зохион байгууладаг "Бага олимп" спортын наадмын Чөлөөт бөх, үндэсний бөхийн төрлөөр 12 сарын 8-нд зохион байгуулсан. Тэмцээнд 4 сургуулийн 90 гаруй тамирчид оролцлоо.

